



## ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/50

Эрдэнэт


### Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн Ээлжит III хуралдааны 4 дүгээр тогтоолоор батлагдсан Орхон аймгийн Засаг дарга бөгөөд Эрдэнэт хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 8.1.4 дүгээр заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн Ээлжит IV хуралдааны 01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн 8.4.2 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Аймгийн “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”, “Бизнесийн форум”- ыг зохион байгуулах Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

Хоёр. “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулахад зарцуулах 5000000 /Таван сая/ төгрөгийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 02 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчилан таниулах, борлуулалтын сувгийг нэмэгдүүлэх зорилгоор үзэсгэлэн яармаг, бизнес эрхлэгчдийг чадавхижуулах ажлыг зохион байгуулах зардал”-аас гаргахыг Санхүү төрийн сангийн хэлтэс /н.Бямбацэцэг/-т зөвшөөрсүгэй.

Гурав: “Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг 2017 оны 2 дугаар сарын 10-ны дотор, “Бизнес форум”-ыг 2017 оны 3 дугаар сарын 20-ны дотор зохион байгуулахыг Ажлын хэсэг /н.Батжаргал/-т даалгасугай.



ЗАСАГ ДАРГА

Д. БАТЛУТ

D:(Zahiramj) A-4 doc

02000 0322

Аймгийн Засаг даргын 2017 оны 2 дүгээр сарын 26 өдрийн 50 дугаар захирамжийн хавсралт

“Бизнес эрхлэгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулах зардал

| Д/д | Задлын нэр                | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгж үнэ | Нийт үнэ         |
|-----|---------------------------|-------------|------------|----------|------------------|
| 1   | Түрээсийн зардал          | цаг         | 3          | 200,000  | 600,000          |
| 2   | АНОНС /2ш/                | м2          | 66         | 6,500    | 429,000          |
| 3   | Урилга хэвлүүлэх          | ш           | 250        | 1,500    | 375,000          |
| 4   | Брошур, хэвлэлийн зардал  | ш           | 250        | 1,600    | 400,000          |
| 5   | Урлагийн номер            | удаа        | 1          | 100,000  | 100,000          |
| 6   | Мандат                    | ш           | 250        | 1,200    | 300,000          |
| 7   | Тараах материал           | ш           | 250        | 4,000    | 1,000,000        |
| 8   | Бичиг хэрэг               | ш           | 250        | 300      | 75,000           |
| 9   | Цэвэр ус                  | багц        | 15         | 4,400    | 66,000           |
| 10  | Тээврийн зардал           |             | 1          | 155,000  | 155,000          |
| 11  | Цайны завсарлага /2 удаа/ | 2 удаа      | 250        | 6,000    | 1,500,000        |
|     | <b>Нийт дүн</b>           |             |            |          | <b>5,000,000</b> |